



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: МУИС-ийн Бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөр

Индекс: E04130201

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Далхжав

Гишүүд: М. Банзрагч

Б.Амарсанаа

Он сар өдөр: 2019-10-10

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- АНУ- Америкийн нэгдсэн улс
- БМИҮЗ-Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- БСШУ- Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
- БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- ЖАЙКА- олон улсын байгууллагын нэр
- МУИС - Монгол улсын их сургууль
- МҮХАҮТ-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
- ОХУ-Оросын холбооны улс
- ХААН- ХААН банк
- ХААИС-Хөдөө аж ахуйн их сургууль
- ШУТ-Шинжлэх ухаан технологи
- ШУТИС-Шинжлэх ухаан технологийн их сургууль
- СиСи- МУИС-ийн дотоод цахим мэдээллийн систем
- ЭШБХ-Эрдэм шинжилгээний бага хурал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС-ийн Бизнесийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Бизнесийн менежмент” “Business management”	
Индекс	E04130201	
Шинжээчид	Багийн ахлагч: Д.Далхжав: ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн санхүүгийн тэнхимийн эрхлэгч Багийн гишүүд: 1. М.Банзрагч: ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал 2. Б.Амарсанаа: СЭЗИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2019-09-13	“Бизнесийн менежмент” магистрын сургалтын өөрийн үнэлгээний тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтнээс хүлээн авах
	2019-09-23	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг бичиж БМИҮЗ-ийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019-09-26-27	Шинжээчид МУИС-ийн Бизнесийн сургууль дээр очиж ажиллана.
	2019-10-07	Шинжээчид үнэлгээний тайланг гаргаж БМИҮЗ-ийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019-10-08	Шинжээчийн өөрийн үнэлгээний тайланг сургуульд илгээнэ.
	2019-10-10	Сургууль шинжээчийн үнэлгээний тайлантай танилцаж тайлбар нотлох баримтыг БМИҮЗ-ийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019-10-11	Шинжээчид сургуулиас ирсэн санал нотлох баримтуудтай танилцаж үнэлгээний тайланг эцэслэнэ.
	2019-10 сард	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчид үнэлгээний тайлангаа танилцуулан хамгаална.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур шаардлагыг шинэчлэн батлах тухай” тогтоол, 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

“Бизнесийн менежмент” магистрын сургалтын хөтөлбөрийг анх 1996 онд боловсруулан баталж, өнөөг хүртэл шинэчлэн сайжруулж ирсэн байна. Хөтөлбөрт улс орны тухайн үеийн нийгэм эдийн засгийн хөгжил, бизнесийн байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг үндэслэл болгон өөрчлөлт шинэчлэлтийг хийж иржээ. “Бизнесийн менежмент” хөтөлбөрөөр суралцан төгсөгчдөд олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадварыг сургалтын чиглэлээс хамааруулж, судалгааны болон мэргэжлийн гэсэн ялгавартай байдлаар томъёолсон байна. Үүнд:

Нэг. /Судалгааны магистр/

Академик компетенц

- Төрийн болон бизнесийн байгууллагын төлөвлөгөө, түүнийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийж чадахуйц мэдлэгтэй;
- Байгууллагыг удирдахад шаардлагатай арга загваруудыг ойлгон мэдэж, тайлбарлах чадвартай;
- Байгууллагад тулгарч буй нөхцөл, шийдвэрлэх асуудал, хүрэхийг хүсэж буй үр дүнгээс хамааруулан эдгээр арга загвараас сонгон хэрэглэх чадвартай мэргэжилтэн /судлаач/ байна.

Судалгааны компетенц

- Судалгааны арга зүйг эзэмшиж, асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;
- Тоон, чанарын, ситуацийн арга хандлага (нөхцөл байдлын) ба бусад бизнесийн судалгаа шинжилгээний арга загваруудыг ашиглан, байгууллагын гадаад, дотоод орчны судалгаа хийж, анхдагч болон хоёрдогч мэдээлэл цуглуулах, түүнд боловсруулалт анализ хийх, нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах чадвартай;
- Бие даан хэрэглээний судалгааг хийж, үндэсний болон гадны улс орнуудын бизнесийн байгууллагын тэргүүн туршлага, судалгааны үр дүнг олон улсын түвшинд танилцуулах, хэвлүүлэн нийтлэх чадварыг эзэмшсэн судлаач байна.

Ерөнхий компетенц

- Ямар ч байгууллага амжилттай оршин тогтнох, хөгжих үндэс болсон хөгжлийн зорилго, стратеги, төлөвлөгөөтэй байхын /өөрөөр хэлбэл стратегийн менежментийн тогтолцоотой байхын/, байгууллагын бүх функциональ нэгж хэсгүүд (маркетинг, бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, судалгаа хөгжил, санхүү, бүртгэл, борлуулалт, хүний нөөц, мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ, хамтын ажиллагаа) хөгжлийн нэгэн зорилгын дор нэгдэн зангидагдаж ажиллахын учир шалтгаан, ач холбогдлыг танин мэдсэн байна. Ингэснээр байгууллагын хөгжлийн асуудлаар олон талыг бодолцсон оновчтой санал санаачилга гарах, өөрийн үүрэгт ажлын хүрээнд байгууллагадаа стратегийн түнш болж ажиллах боломж бүрдэнэ.

Хоёр. /Мэргэжлийн магистр/

Академик компетенц

- Төрийн болон бизнесийн байгууллагын хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийх талаарх онолын цогц мэдлэгтэй;
- Бизнес хэрэглэгдэх арга загваруудыг ойлгон мэдэж, тулгарч буй нөхцөл, шийдвэрлэх асуудал, хүрэхийг хүсэж буй үр дүнгээс хамааруулан үзэл баримтлал, арга загваруудаас сонгон хэрэглэх чадвартай байна.

Судалгааны компетенц

- Байгууллагын орчны нөхцөл байдал, төлөвлөгөөний хэрэгжүүлэлтийн явцыг үнэлэх ситуацийн арга загваруудыг өргөнөөр ашиглан мэдээлэл цуглуулах, түүнд боловсруулалт анализ хийж, хүчин зүйлсийн харилцан хамаарал нөлөөллийг үнэлэх, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг дэвшүүлэн дүгнэх чадвартай байна.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, цаашдын алхмуудыг тодорхойлох, шинэ хандлагуудыг судлах ур чадвартай мэргэжилтэн байна

Ерөнхий компетенц

- Байгууллагыг удирдан зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, ур чадваруудыг эзэмшиж, хэрэглэж чадахуйц;
- Эзэмшсэн менежментийн шинжлэх ухааны мэдлэгийг практикт нэвтрүүлж, шинийг санаачлах, санал боловсруулах гэх мэтчилэн өөрийн санаагаа илэрхийлж чадахуйц (мэргэжлийн дадлага, туршлагатай) ;
- Байгууллагад тулгарч буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг судлан, санал боловсруулж өөрийн боловсруулсан саналыг чөлөөтэй илэрхийлэх чадвартай;
- Өөрийгөө болон багийн гишүүдийг хөгжүүлэх, манлайлах чадвартай мэргэжилтэн байна.

Хөтөлбөрийн сургалтын цагийн багтамжийн хувьд авч үзвэл:

- Анх 1996 онд тус хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхдээ E340100 индекстэй 32 багц цагийн багтаамжтай, үүнээс ерөнхий эрдмийн хичээл 4 багц цаг, мэргэжлийн хичээл 9 багц цаг, мэргэшүүлэх хичээл 9 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 4 багц цаг судалгааны ажил 6 багц цаг байсан бол
- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа магистрын сургалтын хөтөлбөр 2018 онд батлагдсан сургалтын 2 чиглэлтэй боловсруулагдсан байна. Үүнд судалгааны магистрын сургалтын хөтөлбөр 30 багц цаг үүнээс судалгааны арга зүй 3 багц цаг, мэргэжлийн хичээл 6 багц цаг, мэргэшүүлэх хичээл 8 багц цаг, эрдэм шинжилгээний ажлаас 4 багц цаг, магистрын судалгааны ажил 9 багц цаг байна.
- Харин мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт 32 багц цаг бүрдүүлэх бөгөөд үүнээс судалгааны арга зүй 2 багц цаг, мэргэжлийн хичээл 12 багц цаг, гадаад хэл 2 багц цаг, мэргэшүүлэх хичээл 12 багц цаг, дадлагын 4 багц цаг байна. /Хүснэгт 2.4/

Суралцагчид судлах хичээл болон заах багшаа сонгох боломжоор хангагдсан. 11 доктор багштай. Багш тухайн улирлын 11 дэх 7 хоногт дараагийн улиралд заах

хичээлийн хүсэлтээ сургалтын албанд хүргүүлж баталгаажуулдаг. Нэг хичээлийг нэр бүхий 2-оос дээш тооны багш заах боломжийг бүрдүүлсэн. Удирдлагын мэдээллийн “СиСи” нэгдсэн системд багш оюутнууд холбогдож бүх мэдээллээ түүнээс авах боломж бүрдсэн.

Бизнесийн менежмент хөтөлбөрөөр сүүлийн 10 жилд 342 оюутан элссэн ба элсэгчдийн тоог хичээлийн жилээр харуулбал:

- 2009-2010 онд	20
- 2010-2011 онд	11
- 2011-2012 онд	2
- 2012-2013 онд	15
- 2013-2014 онд	13
- 2014-2015 онд	50
- 2015-2016 онд	15
- 2016-2017 онд	18
- 2017-2018 онд	37
- 2018-2019 онд	16
- 2019-2020 онд	45

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Ирүүлсэн өөрийн үнэлгээний тайлангийн 2-6 дугаар хуудсанд магистрын сургалтын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлохдоо өөрийн орны бизнесийн байгууллагын тоо болон мэргэжилтэй ажилтны тооны өсөлтөд судалгаа хийсэн болох нь Хүснэгт 1.2, 1.3, 1.4 Зураг 1.1-ээс харагдаж байна.
- Бизнесийн менежмент магистрын хөтөлбөрөөр төгсөгчид нь бүх төрлийн байгууллагад менежерээр ажиллах боломжтой байдаг тул ажлын байр элбэг байдаг гэсэн дүгнэлтийг гаргасан байна.
- Өөрийн оронд бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, мөн төрийн болон төрийн бус байгууллагуудын судалгааг сүүлийн 5 оноор гаргаж, элсэлтийн квот тогтоохдоо ашигласан байна. /Өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 1.2/

МУИС нь “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөрөө өөрийн улсын ШУТИС, ХААИС-ийн ахисан түвшний сургуулийн хөтөлбөрүүд болон гадны улс орнуудаас Харвардын Бизнесийн сургуулийн “Бизнесийн менежмент”-ийн хөтөлбөртэй

харьцуулан авч үзэж шинэчлэн сайжруулж /өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 7/ иржээ. Мөн, олон улсын нэр хүндтэй нэр бүхий олон сургуулийн магистрын хөтөлбөрт орсон хичээлүүдтэй өөрийн сургуулийн “Бизнесийн менежмент”-ийн хөтөлбөрт ордог хичээлүүдийг харьцуулсан болох нь өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 1.8-аас харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь Бизнесийн менежмент магистрын хөтөлбөрөө өөрийн улсын ШУТИС, ХААИС-ийн ахисан түвшний сургуулийн хөтөлбөрүүд болон гадны улс орнуудаас Харвардын Бизнесийн сургуулийн “Бизнесийн менежмент”-ийн хөтөлбөртэй харьцуулан авч үзэж шинэчлэн сайжруулалт хийдэг. /өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 7/
- Олон улсын нэр хүндтэй нэр бүхий олон сургуулийн магистрын хөтөлбөрт орсон хичээлүүдтэй өөрийн сургуулийн “Бизнесийн менежмент”-ийн хөтөлбөрт ордог хичээлүүдийг харьцуулсан байна. /өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 1.8/

Анхаарах асуудал:

- Өөрийн орны менежерийн эрэлт хэрэгцээг судлахдаа бакалаврын түвшний мэргэжилтэй хүний эрэлт хэд байна, магистрын түвшний мэдлэг чадвартай хүний эрэлт хэрэгцээ хэд байгааг нарийвчлан гаргаж хөтөлбөрийн элсэлтийн квотыг тогтоох нь илүү оновчтой байж болох юм.
- Мөн бизнесийн менежерээр ахисан түвшний мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулиудын элсэлт төгсөлтийн тоог ч бас харгалзан үзэх нь оновчтой байх юм.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд хийсэн судалгаанаас үзвэл нийт төгсөгчийн 90-ээс дээш хувь нь ажлын байртай байна. Энэ нь ажлын байртай элсэгч өөрийн мэдлэг боловсролын түвшнээ ахиулах, ур чадвар нэмэгдүүлэх, шинээр олсон мэдлэг, эзэмшсэн ур чадвар, хандлагаа төлөвшүүлэх зорилгоор элсдэгтэй холбоотой байж болох юм. Иймд тодорхой ажлын байргүй хэдэн хүн элсээд хэд нь төгссөний дараа ажлын байртай болсон бэ? гэдгийг судалгаагаар нарийвчлан харуулбал зохилтой.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчид олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадварыг өөрийн үнэлгээний тайлангийн Хүснэгт 1.11, 1.12-т тодорхойлон харуулсан байна. Судалгааны болоод мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт 3 компетенц болгон харуулсан байна. /Хөтөлбөрийн танилцуулга хэсэгт компетенц тус бүрийг дэлгэрүүлэн харуулсан болно./
- “Бизнесийн менежмент” хөтөлбөрийн зорилгоо *...сургалтын нийтлэг шаардлагын хүрээнд ШУТ-ийн ололт, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан магистрын зэрэг олгох мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино* гэж тодорхойлсон нь ... бүс нутгийн хэмжээнд “Либерал Арт” уламжилалд суурилсан судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтах гэсэн МУИС-ийн, ... эрдэмд суралцаж, мэдлэг хуримтлуулан, түүнийгээ хөдөлмөрийн зах зээлд хэрэглээ болгох чадвартай, судалгааны арга барил эзэмшсэн бүтээлч мэргэжилтэн бэлтгэх гэсэн Бизнесийн сургуулийн эрхэм зорилгуудтай уялдаж чадсан байна.
- МУИС болон Бизнесийн сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг олон арван байгууллага, аж ахуйн нэгжүүд байдаг бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд хамтын ажиллагаатай 9-10 нэгж байдаг болох нь сүүлийн 3 жилийн баримт материалаар батлагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хамтын ажиллагааны хүрээнд авч үзвэл 2016-2018 оны байдлаар жилд дунджаар 9-10 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан.
- Төгсөгчид олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадвар, төлөвшүүлэх хандлагыг 3 компетенц болгон харуулсан.
- Тус хөтөлбөрөөр элсэгчдийн сүүлийн 10 жилийн судалгаанаас үзвэл тооны хойноос хөөцөлдөх бус чанарыг эрхэмлэсэн болох нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл: нэг багшид ногдох магистрын тоо /ачаалал/ бага байх нь багшийн хүртээмж сайн, багш оюутантай ажиллах цагийн боломжийг олгож буй хэрэг гэж үзэж болох юм.

Анхаарах асуудал:

- ШУ-ы ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх суралцагчдыг үйлдвэрлэл дээр мэргэшүүлэхэд илүү анхаарч мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт үйлдвэрлэлийн дадлага хийх багц цагийг нэмэгдүүлэхэд анхаарах /төгсөгчдөөс гарсан санал/

Зөвлөмж:

- Хөтөлбөр боловсруулахдаа төгсөгчид, ажил олгогчид, суралцагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

• Илрэл нотолгоо:

- Бизнесийн менежмент магистрын сургалтын хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадварыг тодорхойлохдоо Мэргэжлийн магистрын түвшинд, Судалгааны магистрын түвшинд гэж 2 ангилан боловсруулжээ. Суралцагчид олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадварыг ямар хичээлүүдээр олгохыг нарийвчлан гаргаж өгсөн байна. Судлах хичээлүүдээр олгох цогц чадамжийг сургалтын 2 чиглэлийн дагуу тус бүрд нь 3 компетенцэд хуваан гаргасан.
- Хөтөлбөр боловсруулах батлах үйл ажиллагаа нь дараах үе шатыг дамжин хэрэгждэг байна. Үүнд:
- Тэнхимийн хөтөлбөрийн хорооны 2017 оны 11 сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөрийг хэлэлцээд сургуулийн хөтөлбөрийн хороонд уламжилсан байна. Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хороо 2017 оны 12 сарын 08-нд хуралдаж “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөрийг МУИС–ийн хөтөлбөрийн ерөнхий хороонд уламжилсан байна. “Бизнесийн менежмент” сургалтын хөтөлбөр 2018 оны 01 сарын 22-ны өдөр сургалтын нэгдсэн газрын даргын шийдвэрээр батлагдсан байна.
- Хөтөлбөрт орсон хичээлүүдийг ерөнхий суурь хичээлүүд, мэргэжлийн хичээлүүд, мэргэшүүлэх хичээлүүд гэж 3 ангилан төлөвлөсөн. Суралцагчдын чөлөөтэй сонгон суралцах боломжийг олгосон, гэхдээ хичээл хоорондын залгамж холбоо уялдааг харуулсан онцлогтой болсон. /өөрийн үнэлгээний тайлангийн 19-20 дугаар хуудас/
- МУИС-ийн захирлын 2017 оны А/410 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг баримтлан элсэлт сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Оюутны мэдлэг, ур чадварыг МУИС-ийн захирлын 2015 оны А/203 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын журам”-ыг баримтлан үнэлдэг байна. /Өөрийн үнэлгээний тайлан 21 дүгээр хуудас, Магистрын сургалтын хөтөлбөр баримт бичигт орсон тушаалуудын хуулбараас/
- Сургалтын арга зүй, заах арга, хэлбэр үнэлгээний тогтолцооны өөрчлөлт зэрэгт SWOT шинжилгээ хийж давуу болон сул талаа тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүй, заах арга, хэлбэр үнэлгээний тогтолцооны өөрчлөлт зэрэгт SWOT шинжилгээ хийж давуу болон сул талаа тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг график матриц байдлаар дүрслэн харуулж, оюутан нэг хавтгайгаас харах боломжийг бүрдүүлэх. Хичээл болгоноос олгох онолын мэдлэг, эзэмшүүлэх ур чадвар, төлөвшүүлэх хандлагыг харуулсан зураглал гаргах

Зөвлөмж:

- Ямар хичээлүүдээр ямар мэдлэгүүдийг олгох вэ? Ямар хичээлийн ажилбаруудаар ямар чадвар эзэмшүүлэх вэ? Оюутан төгсөөд гарахад ямар хандлага төлөвшсөн хүн байх вэ? гэдгийг харуулсан зураглал боловсруулбал элсэгчид болон ажил олгогчид илүү ойлгомжтой болох юм.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 3 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангасан гэж дүгнэгдсэн тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж үнэлэв.

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- “Бизнесийн менежмент” магистрын сургалтын төлөвлөгөөг 1996 оноос өнөөг хүртэл шинэчилж ирэхдээ тухайн үеийн нийгэм эдийн засгийн хөгжил, бизнесийн байгууллагуудын хэрэгцээ шаардлагын дагуу өөрчлөгдөж ирсэн байна.
- Анх 1996 онд тус хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхдээ E340100 индексдэй 32 багц цагийн багтаамжтай, үүнээс ерөнхий эрдмийн хичээл 4 багц цаг, мэргэжлийн хичээл 9 багц цаг, мэргэшүүлэх хичээл 9 багц цаг, эрдэм шинжилгээний ажил 4 багц цаг, судалгааны ажил 6 багц цаг байсан бол

- Одоо магистрын сургалтын хөтөлбөр нь 2 чиглэлтэй боловсруулагдсан байна. Үүнд судалгааны магистрын сургалтын хөтөлбөр 30 багц цаг үүнээс судалгааны арга зүй 3 багц цаг, мэргэжлийн хичээл 6 багц цаг, мэргэшүүлэх хичээл 8 багц цаг, эрдэм шинжилгээний ажлаас 4 багц цаг, магистрын судалгааны ажил 9 багц цаг байна.
- Харин мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт 32 багц цаг бүрдүүлэх бөгөөд үүнээс судалгааны арга зүй 2 багц цаг, мэргэжлийн хичээл 12 багц цаг, гадаад хэл 2 багц цаг, мэргэшүүлэх хичээл 12 багц цаг, дадлагын 4 багц цаг байна. /өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 2.4/
- Судалгааны болон мэргэжлийн магистрын компетенц /цогц чадамж/-ийг Хүснэгт 2.1-д маш ойлгомжтой товч тодорхойлон харуулсан байна.
- Суралцагчид судлах хичээл болон заах багшаа сонгох боломжоор хангагдсан байна. Багш тухайн улирлын 11 дэх 7 хоногт дараагийн улиралд заах хичээлийн хүсэлтээ сургалтын албанд хүргүүлж баталгаажуулдаг байна. Нэг хичээлийг 2-оос дээш тооны багш заах боломжийг бүрдүүлсэн байдаг. Энэ чиглэлээр өөрийн үнэлгээний тайлангийн 28 дугаар хуудсанд дэлгэрэнгүй мэдээлжээ.
- Удирдлагын мэдээллийн “СиСи” нэгдсэн систем олон жил туршигдан улам бүр сайжирч багш, оюутан, суралцагчид бүх мэдээллээ түүнээс авах боломж бүрдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл /Туршлага

- Суралцагчид судлах хичээл болон заах багшаа сонгох боломжоор хангагдсан байна. Багш тухайн улирлын 11 дэх 7 хоногт дараагийн улиралд заах хичээлийн хүсэлтээ сургалтын албанд хүргүүлж баталгаажуулдаг байна. Нэг хичээлийг 2-оос дээш тооны багш заах боломжийг бүрдүүлсэн байдаг. Энэ чиглэлээр өөрийн үнэлгээний тайлангийн 28 дугаар хуудсанд дэлгэрэнгүй мэдээлжээ.
- Удирдлагын мэдээллийн “СиСи” нэгдсэн систем олон жил туршигдан улам бүр сайжирч багш, оюутан, суралцагчид бүх мэдээллээ түүнээс авах боломж бүрдсэн.
- Магистрын хөтөлбөрт хичээлийн сонголт чөлөөтэй, олон хичээлээс сонгон судлах боломжийг бүрдүүлж өгч чадсан судалгааны магистрын хөтөлбөрт судалгааны ажлын багц цагийг 9 байхаар төлөвлөсөн. Энэ нь судалгаанд илүү ач холбогдол өгч академик сургалтаас аль болох татгалзаж судалгаа шинжилгээ инновацын чиглэлд хандуулах гэсэн сайн тал ажиглагдаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулахдаа гадны өндөр хөгжилтэй улс орнуудын сургалтын төлөвлөгөөг харгалзан үзсэн боловч хэрэгжилтийг үнэлсэн **шинжилгээ** харагдахгүй байна.
- Урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах чиглэлтэй хичээл сургалтад оруулж өгөх шаардлага ажил олгогчдод гарч байгааг анхаарч үзэх.

Зөвлөмж:

- Харин мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт мэргэшүүлэх дадлагын цагийн багтаамжийг 4 багц цагаар төлөвлөж оруулсан нь академик чиглэлд илүү анхаарсан байж болзошгүй. Цаашид аль болох танхимын сургалтаас татгалзаж мэргэшүүлэх дадлага хийх шилдэг менежер бэлтгэхэд арга барилыг үйлдвэрлэлийн орчинд илүү хандуулах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын арга зүй боловсруулахад дараах баримт бичгүүдийг үндэслэл болгосон байна. Үүнд:

- БШУ-ы сайдын 2014 оны А/370 тоот тушаалаар батлагдсан Магистр, докторын сургалт эрхлэх журам
- МУИС-ийн захирлын 2014 оны А/347 тоот тушаалаар батлагдсан МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам
- МУИС-ийн захирлын 2015 оны А/203 тоот тушаалаар батлагдсан МУИС-ийн сургалтын журам

Сургалтад хэрэглэж буй аргууд, цахим программ хангамж, мэдээллийн технологийн талаар өөрийн үнэлгээний тайлангийн 34-37 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулж илтгэсэн байна.

- Суралцагчид сургуулиас авах өөрт шаардлагатай мэдээллийг СиСи цахим программын хүрээнд бүрэн авах боломж бүрдсэн ашиглалт сайн, багш оюутнууд бүрэн ашиглаж чаддаг байна. /Багш, оюутантай уулзсан уулзалтын тэмдэглэлээс/
- МУИС-ийн төв номын сан нь “Бизнесийн менежмент” магистрын сургалтын хөтөлбөрөөр суралцагчид чиглэгдсэн 2 тусгай танхимтай, өөрийн орны эрдэмтдийн бизнесийн менежментийн чиглэлээр хийсэн судалгааны ажлыг цахим хэлбэрт оруулж сургалтад ашиглах боломж олгосон.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх заавар зөвлөмжүүд хангалттай гаргасан байна.
- Цахим номын фондыг баяжуулж сургалтад ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Өнөөдөр хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлага хаашаа явж байна. Бид тэр зүгт явах ёстой. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологид илүү анхаарал хандуулах. /ажил олгогчдоос гарсан санал/
- Магистр хүн ажил дээр гараад сурах биш сурчихсан байх шаардлагатайг ажил олгогчид хүсэж байна. /ажил олгогчдоос гарсан санал/
-

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрантуудын үнэлгээ, багшийн үнэлсэн үнэлгээний тархалтын талаар өөрийн үнэлгээний тайлан хүснэгт 2.10, зураг 2-4 –д харуулсан байна.
- Суралцагчийн үнэлгээг өөрийн үнэлгээний тайлангийн 2.11, 2.12-д дэлгэрэнгүй харуулсан байна.
- Хөтөлбөрийн явцад оюутны мэдлэг, хандлага, ур чадварын түвшинг тогтоож, үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлдэг үнэлгээний арга аргачлалыг өөрийн үнэлгээний тайлангийн 39 дүгээр хуудас хүснэгт 2.11, 2.12-оос харж болохоор байна.
- Суралцагчийн сурлагын амжилт, ахиц дэвшлийн талаар статистик мэдээлэл гаргаж харуулсан байна. /Өөрийн үнэлгээний тайлангийн 41-42 дугаар хуудас/

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч оюутны мэдлэг, хандлага, ур чадварын түвшинг тогтоож, үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлдэг үнэлгээний аргуудыг багш бүр өөрийн заадаг хичээлүүдийн онцлогт нийцүүлэн гаргаж ашигладаг болох нь суралцагч болон төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтаар батлагдаж байсан.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 3 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангасан тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Бизнесийн сургуулийн одоогийн байрлаж байгаа хичээлийн 4-р байр 1957 онд баригдсан ашиглалтын хугацаа дууссан 2017 онд засвар үйлчилгээ хийсэн одоо ашиглаж байна. Харин хичээлийн 5 дугаар байр нь 2005 онд шинээр ашиглалтад оржээ. 2016 оноос эдийн засгийн хөтөлбөрүүд салж өөр байрлалд шилжсэнээр тус сургуулийн сургалт явуулах орчин, анги танхим хүрэлцээ хангамж сайжирсан байна. Цаашид сургуулийн барилга шинэчлэх чиглэлтэй байгаа тул сургалтын орчин улам бүр сайжрах боломж бүрдэнэ гэсэн тайлбарыг сургуулиас өгч байна.
- Сургуулийн номын сангийн үйлчилгээ хүрэлцээ хангамж сайн, төв номын санд бизнесийн менежмент мэргэжлийн чиглэлээр хичээл сургалт явуулахаар тоноглогдсон 2 лабораторитой, суудал багтаамж хүртээмжтэй байдаг болох нь багш оюутантай хийсэн уулзалт, МУИС-ийн төв номын сангийн үйл ажиллагаатай танилцах явцад батлагдаж байлаа.
- МУИС-ийн Бизнесийн сургуульд магистрын хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудаас сургалтын орчин, техник хэрэгслийн хангамжийн талаар авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн хангалттай болохыг баталж байна.
- Мөн өөрийн үнэлгээний тайлангийн 46-56 дугаар хуудас хүснэгт 3.1, 3.2 ,3.3, 3.4, 3.5, 3.6-д тус сургуулийн хичээлийн байрны хүрэлцээ хангамж, онцлох үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй харуулсан статистик судалгааг гаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн V байр 2005 онд шинээр ашиглалтад орсон, сургуулийн хичээлийн төв байрны анги танхимуудыг 2017 онд бүрэн засаж тохижуулсан.
- Хичээлийн байр нь анх сургалт явуулах стандартын дагуу баригдсан бөгөөд лекц, семинар, лаборатори, компьютерын танхимын 1 оюутанд ногдох дундаж талбай 1.8м² байгаа нь стандарт шаардлага хангасан.
- Багшийн ажиллах орчин, нөхцөл бүрэн хангагдсан байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн зарим анги танхимын тоноглол, тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар шинэчлэх;
- Багш нар хичээлийн бус цагт оюутантай ажиллах, зөвлөгөө өгөх өрөө тасалгааны боломжийг бүрдүүлж өгөх;

Зөвлөмж:

- Магистр оюутанд багаар болон бие даан ажиллах, судалгаа хийх;
- Лаборатори, өрөөг гарган тохижуулах, интернэтийн орчинг сайжруулах;

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн менежмент магистрын хөтөлбөрөөр суралцаж байгаа магистрантууд судлаач багш нар лицензтэй 6 программ ашиглаж байгаагаас гадна, хичээл практикийн материаллаг нөөц, үзүүлэн, хэвлэмэл хуудас, тараах материалууд хүртээмжтэй байна.
- Тус хөтөлбөрт хичээл зааж байгаа багш нар нэмэлтээр уншиж судлах материал ном, гарын авлагыг оюутнуудад ихэвчлэн цахим файл хэлбэрээр өгдөг бөгөөд үүнд сургуулийн дотоод мэдээллийн цахим сүлжээ СиСи программаа ашиглаж байна.
- Сургуулийн төв номын сангаас өөрийн сургуулийн эрдэм шинжилгээний ихэнх бүтээлүүдийг цахим хэлбэрт оруулан оюутнууд сүлжээгээр гэрийн нөхцөлд ч татан ашиглах боломжийг бүрдүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- OpenEdx ашиглан олон улсын түвшинд E-контент боловсруулан ашиглах бэлтгэл ажил хангагдсан, 6 хичээлээс 2 хичээл нь хийгдэж байна.
- Лицензтэй 6 болон нээлттэй программ хангамжийг ашигладаг.

Анхаарах асуудал:

- Сургалт, дадлага болон судалгааны ажлын удирдамж, заавар болон зөвлөмжийг шинэчлэх;
- Шаардлагатай программ хангамжийг худалдан авах, лицензийг сунгах;

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайлангийн шалгуурын нотлох баримтуудыг дэлгэрэнгүй бичиж шинжээч уншиж ойлгох болон танилцахад хялбар байдлаар бэлтгэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС–ийн хэмжээнд 2010 оноос эхлэн сургалтын үйл ажиллагаанд СиСи цахим программыг бүрэн ашиглалтад оруулснаар суралцагчдын хичээл сонголт, дүнгийн мэдээлэл, сургууль, сургалтын албатай холбоотой мэдээллийг өдөр тутам авах боломж бүрджээ.

- Мөн МУИС-ийн num.edu.mn, SiSi num.edu.mn, Бизнесийн сургуулийн bs.num.edu.mn Номын сангийн catalog.num.edu.mn зэрэг вэбсайт цахим эх үүсвэрүүдийг ашиглах боломж бүрджээ.
- МУИС-ийн төв номын сан нь 2142,19 м2 талбайтай, 638 хүний суудалтай, 44 компьютер, монгол хэлээр 188,6 мянга, орос хэлээр 130,9 мянга, англи хэлээр 37,7 мянга, бусад хэлээр 700 гаруй ном, сурах бичиг, гарын авлагатай, докторын диссертаци 650, магистрын дипломын ажил 6300 гаруй байна.
- Номын сангийн үйл ажиллагааг цаашид улам бүр өргөжүүлэх зорилготой бөгөөд одоогоор дараах боломжууд суралцагчид олгогдсон байна. Үүнд:
 - ✓ Цахим ном унших боломжтой
 - ✓ Электрон каталогитой
 - ✓ Коха программ ашигладаг
 - ✓ Номын сангийн орчинд интернет ашигладаг
 - ✓ Оюутнууд дотуур байрнаас электрон каталоги шүүх ном захиалах боломжтой
 - ✓ Ганцаарчлан болон бүлгээр сууж ажиллах өрөөнүүдтэй
 - ✓ Номын сангийн программд шинэчлэл сайжруулалтыг байнга хийдэг зэрэг нь

өөрийн үнэлгээний тайлан, ахисан түвшний оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, оюутнуудтай хийсэн уулзалт, ярилцлага, номын сангийн үйл ажиллагаатай очиж танилцах явцад ажиглагдсан болно.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн үйлчилгээ, орчин нь олон жишигт нийцсэн;
- Ахисан түвшний оюутнуудад зориулсан нийтийн болон ганцаарчилсан уншлагын өрөөтэй;
- Онлайн мэдээллийн сангуудыг ашиглахаас гадна өөрсдийн боломжоор хөгжүүлсэн, диплом, судалгааны ажлуудыг унших бүрэн боломжтой;

Анхаарах асуудал:

- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хэлэлцдэг байх, гарсан санал шүүмжийг арилгах тал дээр анхааран ажиллах;

Зөвлөмж:

- Магистрын түвшинд ашиглагдах ном сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх;

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 3 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангасан тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой

хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг хэрхэн хангаж ажилладаг талаар өөрийн үнэлгээний тайлангийн 72-82 дугаар хуудсанд дэлгэрэнгүй тайлагнаж зураг 4.1, 4.2, Хүснэгт 4.2, 4.3 тодорхой харуулсан байна.
- “Бизнесийн менежмент” магистрын сургалтын хөтөлбөр боловсруулж, батлах хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа БСШУ-ы сайдын 2007 оны А/187 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, 2014 оны А/370 тоот тушаалаар батлагдсан Магистр докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах дүрэмд өөрчлөлт оруулах тухай” эрхийн актуудыг үндэслэл болгодог байна.
- Мөн үүний зэрэгцээ МУИС-ийн захирлын 2016 оны А/235 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”, мөн оны А/112 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцох түр журам” зэргийг дагаж мөрддөг байна.
- МУИС-ийн захирлын 2016 оны 12 сарын 03-ны өдрийн А/347, “Хөтөлбөрийн хорооны журам” батлах тухай тушаал,
- Хөтөлбөрийн хороо, тэнхим, профессорын багийн хурлын тэмдэглэл
- МУИС-ийн хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн тайлан

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- “Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтад тэнхим, сургуулиас гадна МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, сургалтын нэгдсэн алба оролцдог” гэдэг нь онцлог боловч тухайн хороо, албанд мэргэжлийн хүн байгаа эсэх нь эргэлзээ төрүүлж байна.
- Тэнхим болон салбар дундын ерөнхий хороо ажилладаг.
- Аливаа шатны хөтөлбөрийн хороо нь тогтсон хугацаанд материал хүлээн авч, тогтсон хугацаанд шийдвэрлэн идэвхтэй ажилладаг байна.
- Өргөдөл, гомдлын статистик гаргадаг.

Анхаарах асуудал:

- Гомдол, санал барагдуулсан болон төлөвлөгөөний биелэлт, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэн, дүгнэдэг байх, протоколоор баталгаажуулах;

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайлангаас шинжээч шалгуурын нотлох баримтуудыг уншиж ойлгох болон танилцахад хялбар, эмх цэгцтэй байдлаар бэлтгэх;

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Бизнесийн менежмент хөтөлбөрийн багш суралцагч 2013-2018 онд дотоод гадаадын байгууллагуудтай 41 төсөл хөтөлбөрт хамтарч ажилласан байна. Хамтын ажиллагаатай байгууллагуудаас заримыг тоймлон дурдвал ХААН банк, Голомт банк, МҮХАҮТ, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Банк санхүүгийн академи, Монгол, Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Швейцарын хөгжлийн агентлаг, ЖАЙКА олон улсын байгууллага, Дэлхийн банк, АНУ-ын Ладос олон улсын институт зэрэг 20 гаруй байгууллагыг нэрлэж болохоор байна.
- Хамтын ажиллагааны чиглэлээр өөрийн үнэлгээний тайлангийн 82-88 дахь хуудсанд дэлгэрэнгүй илтгэсэн байна.
- Мөн Багшийн бүтээлийн жагсаалт, тайлан, профессор багш нарын Б цагийн тооцоо, тайлан №4, №5
- Дэд профессорын албан тушаалын зэрэглэлийн материалын өөрийн үнэлгээний тайлан
- МУИС, Бизнесийн сургуулиас зохион байгуулдаг болон тэнхимийн хийсэн судалгаанууд зэрэг нь баталгаажуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад, дотоод хамтын ажиллагаа сайн хөгжсөн.
- Тэтгэлэг болон төслүүд нь сургуулийн албан ёсны цахим хуудсаар зарлагддаг.

Анхаарах асуудал:

- Гэрээт ажил, төсөл хөтөлбөрүүдийн гэрээг багшийн Б цагийн тайлангаас харах нь хүндрэлтэй байсан тул тэнхимийн нэгдсэн мэдээллийн сан бий болгон ажиллах;

Зөвлөмж:

- Дотоодын их дээд сургуулиудтай сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллах;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн санхүүжилтээс тэнхим, хөтөлбөр хэрэгжүүлэгч багш суралцагчид хэрхэн хувь хүртээдэг, сургалтын өртөг зардлын тооцоолол зэргийг өөрийн үнэлгээний тайлангийн 88-96 дугаар хуудсанд Хүснэгт 4.8 –д хичээлийн жил тус бүрээр дэлгэрүүлж илтгэсэн байна.
- Одоогоор тус хөтөлбөрийн сургалтын багц цагийн төлбөр 77,3-100,7 мянган төгрөгийн хооронд байна. Харин улирлын суурь хураамжийг оюутнуудаас авдаг бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой 112,0 мянган төгрөг орчимд байна.
- Нэг оюутанд ногдох өртөг 1,4 сая төгрөг байна. /Бизнесийн сургуулийн санхүүгийн тайланд үндэслэн тооцсон үр дүн/
- Хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн шинэчлэлт өөрчлөлтөд зориулсан төсөв гаргадаг байна. Тухайлбал, 2015-2017 оны хооронд зарцуулсан төсвийг өөрийн үнэлгээний тайлангийн 93 дугаар хуудсанд Хүснэгт 4.12-т тодорхой харуулсан байна. Үүнийг нотлох дараах баримтууд байна. Үүнд:
 - Бизнесийн сургуулийн тайлан баталгаажуулах баримт бичгүүд
 - 2018 оны санхүүгийн тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- “Бизнесийн менежмент” магистрын сургалтын хөтөлбөрт багтсан хичээлүүд тус бүрээр сонгон суралцсан оюутны тоо, орсон орлогыг сүүлийн 5 хичээлийн жилээр нэг бүрчлэн түүвэрлэн гаргасан нь онцлог байлаа. /Өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 4.8/
- Магистрт суралцагчдын сургалтын төлбөрийн улиралын суурь хураамж сүүлийн 5 жилд өсөлт багатай тогтвортой явж ирсэн онцлогтой. /Өөрийн үнэлгээний тайлан Хүснэгт 4.9 100,0-112,0 мянган төгрөг/

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэнхим, сургуульд оруулж буй орлого, зардлын тооцоог хийдэг байх;

- Сургалтын төлбөрийн орлогоос гадна төсөл хөтөлбөрөөс орж ирэх мөнгөн хөрөнгийн задаргааг тайланд тусгах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн орлого зардлын тооцоог тэнхим өөрийн нөөц бололцоонд тулгуурлан хийдэг болох;
- Төсөл, гэрээт ажилд оюутны оролцоо тоог нэмэгдүүлэх, баримтаар баталгаажуулан тайланд тусгах;
- Төсөл, гэрээт ажилд оюутныг хэрхэн оролцуулж, цалинжуулдаг талаар тайланд тусган баримтаар нотлох шаардлагатай.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг цаашид тогтвортой хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрийн зах зээл дээр тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн эрэлт хэрэгцээ хэр байгааг тогтоох тандан судлах үйл ажиллагааг явуулдаг байна. Мөн үүний зэрэгцээ төгсөгчдийн ажил, албан тушаал дэвшсэн байдал, хөдөлмөр эрхлэлт ажил мэргэжлийн тохирц гэх мэтийг тогтоох тандан судлах үйл ажиллагааг явуулахаар төлөвлөсөн байна. /Магистрын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан 96 дугаар хуудас/
- Хөтөлбөрийн сурталчилгаа идэвхжүүллийн арга хэлбэр, хүртээмж үр нөлөөнд анхаарал хандуулж шинээр элсэгчид болон суралцагчид зориулсан тэнхимийн өдөрлөг, багш оюутны уулзалт, нээлттэй лекц семинар, хөтөлбөр сурталчлах өдөрлөг зэргийг явуулдаг байна. /Магистрын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан 97 дугаар хуудас/
- Ахисан түвшний суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, мөшгих судалгааны тайлан баталгаажуулсан баримт бичгүүд
- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангаж буй гол хэрэгсэл нь сургуулийн цахим мэдээллийн СиСи программ байдаг. Тус системийн үйл ажиллагааг өөрийн үнэлгээний тайлангийн 99 дүгээр хуудас Зураг 4.6-д тодорхой харуулсан байна. Дараах нотлох баримтуудаар баталгаажсан. Үүнд:
 - Оюутнуудтай хийх уулзалт
 - “Career fair” арга хэмжээний тайлан
 - Ажил олгогч, төгсөгч нартай хийсэн ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- “Career fair” арга хэмжээ нь МИУС-ийн хэмжээнд зохион байгуулдаг нэгдсэн ажил болсон байна.
- Мөшгих судалгааг 2016 оны төгсөгчдөөс эхлэн авахаар график гарган ажиллаж байна.

- Өнгөрсөн хавар тэнхимийн 60 жилийн ойгоор хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг олон нийтийн сүлжээ ашиглан багагүй хэмжээнд хийж чадсан байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогч болон төгсөгчдөөс гарсан санал, шүүмж, хүсэлтийг хөтөлбөрт тусгадаг эсэхийг баримтаар нотлох.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг элсэлтийн үед л олон нийтэд хүргэдэг байдлыг засах, цахим хэлбэрээр олон нийтэд байнга тогтмол хүргэдэг байх;
- Тэнхимийн өдөрлөг, багш оюутны уулзалт, яриа, нээлттэй лекц, семинар, хөтөлбөр сурталчлах өдөрлөг зэрэг тэнхимээс зохион байгуулдаг ажлын тайлан, баталгааг тайланд оруулан баталгаажуулах;

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангаж буй гол хэрэгсэл нь сургуулийн цахим мэдээллийн СиСи программ байдаг. Тус системийн үйл ажиллагааг өөрийн үнэлгээний тайлангийн 99 дүгээр хуудас Зураг 4.6-д тодорхой харуулсан байна.
- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангах нэгэн хэрэгсэл нь тус сургуулийн албан ёсны нээлттэй харьцах цахим хаяг болох <https://www.num.edu.mn/academics> болон <http://bs.num.edu.mn> сайтууд юм. Эдгээр сайтад хөтөлбөрийн талаар шинэчилсэн мэдээллүүдийг тогтмол тавьж нийтийн хүртээл болгодог байна. Үүнийг төгсөгчид болон ажил олгогчдын төлөөлөл, оюутнуудтай хийсэн ярилцлага баталж байна.
- Ажил олгогч, төгсөгч нартай хийсэн ярилцлагын тэмдэглэл
- Оюутнуудтай хийсэн ярилцлагын тэмдэглэл
- МУИС болон бүрэлдэхүүн Бизнесийн сургуулийн албан ёсны веб хуудас, хандалтын тоо
- Багш нарын цагийн тооцооны хуудас, тв ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын нэгдсэн мэдээллийн системээр бүх мэдээлэл дамжин, сонирхогч талуудад хүрдэг.
- Сургуулийн албан ёсны веб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргүүлдэг.

- ОСW ашиглан багш нарын үүсгэсэн нээлттэй хичээлийг цахим хэлбэрээр үзэх боломжтой.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 5 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангасан тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д элсэх журмын дагуу нэгдсэн байдлаар элсэлтийн шалгалт авдаг /бүртгэлийн нэгдсэн сайт болох <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулдаг/ Тухайн хөтөлбөрт ноогдох квотод багтаан элсэлтээ авах бөгөөд элсэгчдээс авах шалгалтыг тест болон ярилцлага хийх замаар дүнг гаргаж магистрантуудаа элсүүлдэг болох нь нотлогдсон. /2019 оны 5-р сарын 31-ний шинэ элсэлтийн журам батлагдсан/
- Хүсэлт гаргасан болон элссэн магистрантын тоог харьцуулсан дата цуглуулдаггүй байсан байна. Дээрх мэдээллийг нэгдсэн мэдээллийн сангаас харсан болно.
- Гадаад оюутан нийт 7 суралцсанаас БНХАУ-аас 5, ОХУ-аас 2 оюутан хүрэлцэн ирж суралцсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийн тестийг мэргэжлийн сургууль тус бүрээр боловсруулдаг.
- Ярилцлагыг мэргэжлийн тэнхим явуулдаг давуу талтай.

Анхаарах асуудал:

- Цаашид ярилцлагын дүнгээс гадна элсэгч тус бүртэй хийсэн ярилцлагын протокол хөтлөх нь үнэлгээний үндэслэл болох давуу талтай байх болно
- Хэдийгээр элсэлтийн журмын дагуу мэргэжлийн сургуулиуд шалгалтын материалыг боловсруулж байгаа ч, МВА зэрэглэлд нийцэхүйц цогц байж чаддаггүй /үндэслэл: төгсөгч, суралцаж буй магистрантуудтай хийсэн ярилцлагын үр дүн/

Зөвлөмж:

- Магистрт урьд өмнө баклавын түвшний мэргэжил эзэмшсэн тодорхой мэдлэг, чадвартай хүмүүсийг элсүүлэхдээ хандлага, ур чадваруудыг үнэлэх даалгаврын хувийг ихэсгэх нь зүйтэй.
- Мөн МВА-д ноогдох квотын хэмжээг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байгаа тул 5 жилд 81 төгсөгчтэй байх нь МУИС-ийн хувьд маш бага тоо байгааг анхаарах нь зүйтэй.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны гарын авлагатай /Суралцагчийн гарын авлага 2017 он. 24-26 хуудсанд магистрын хөтөлбөрийн мэдээлэл дэлгэрэнгүй орсон байна/ Тэнхимийн багш нар болон удирдагч багш нар магистрантуудтай хамтран төлөвлөгөө боловсруулж батлуулан түүний дагуу ажилладаг болох нь төгсөгч болон суралцаж буй магистрантуудтай хийсэн ярилцлага, багш нарын хувийн хавтсанд байгаа удирдсан магистрантуудын төлөвлөгөөгөөр баталгаажиж байна.
- Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг /хөтөлбөрийн тайлангийн 108-110-р хуудсанд харуулсан хүснэгт 5.4/ ба хэдийгээр тайланд сэтгэл ханамжтай гэж дүгнэсэн байгаа ч газар дээр нь судалгаатай танилцахад магистрын хөтөлбөрийн хүрээнд сэтгэл ханамж буурч байгаа үзүүлэлтүүд ажиглагдсан.
- Магистрантуудын ЭШБХ хурал зохион байгуулж, оролцуулдаг. /Бүтээлийн жагсаалтын хавтаснаас харахад магистрантууд удирдагч багштай хамтран мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн илтгэл, өгүүлэл, судалгааны ажил, ЭШБХ-ын хөтөлбөрт орсон жагсаалтаар батлагдаж байна/

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийн зарим хэсгийг бүрэн хангаагүй тул **Хэсэгчлэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Бүх хөтөлбөрт суралцагчдад зориулсан дэлгэрэнгүй гарын авлагатай.
- Магистрантуудын хувьд ганцаарчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулдаг.

Анхаарах асуудал:

- Зохион байгуулалттайгаар тэнхимийн зүгээс дэмжиж, зөвлөх бүрэн боломжтой тул цаашдын үйл ажиллагаанд албан ёсоор төлөвлөж оруулах.
- МУИС-ийн захиргааны нэгжид харьяалагдах оюутны хөгжил, үйлчилгээний газар нь бакалавр оюутнуудад илүү анхаарал хандуулаад магистрантуудыг дэмжин туслах үйлчилгээг хангалттай үзүүлж чадахгүй байгааг цаашид анхаарах.

Зөвлөмж:

- Магистрын түвшинд суралцагчдад тусгайлан үзүүлэх хөгжлийн бодлого, үйлчилгээ үзүүлэх хэлтэс, алба, нэгж дутмаг байна. Энэ үүргийг магистр оюутны удирдагч багш нар биелүүлж байгаа нь анзаарагдсан тул бакалаврын түвшний оюутнуудтай энэ зэрэгцэхүйц хэмжээнд магистр оюутнуудын хөгжлийг сургуулиас дэмжих.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубийг зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ байхгүй.
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал байхгүй.
- Захиргааны туслах, судалгааны ажлын туслахаар тус бүр нэг магистрант ажилласан мэдээлэл байна.
- Цагийн болон үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоо мэдээлэл байхгүй.
- Олимпиад, уралдаан тэмцээнд магистр оюутан оролцсон мэдээлэл байхгүй.
- Урамшуулал, тэтгэлэгт хамрагдсан магистрант байхгүй.
- МУИС-ийн Бизнес удирдлагын магистрын хөтөлбөрийг боловсруулахдаа бодлогын хүрээнд нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагааг төдийлөн оруулж өгөөгүй тал анзаарагдаж байна.
- Магистрт суралцагчдын онцлогийг харгалзан үзэж төслийн хичээлүүдээр дамжуулан олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах ажил хийгдээгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийн заалтуудыг бүрэн хангаж чадаагүй тул **Хангаагүй** гэж дүгнэв.

Анхаарах асуудал:

- Олон нийтийн оролцоонд анхаарал хандуулсан гэх нотлох баримт олдохгүй байгааг анхаарах;
- Магистрантуудын тэтгэлэг, тэтгэмж, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх;
- Ажилгүй байсан магистрантуудыг ажлын байранд зуучилж өгөх;
- Магистрантуудыг суралцах хугацаанд нь уралдаан тэмцээнд оролцуулахад анхаарах;

Зөвлөмж:

- Магистрантуудын, нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар сургалтын хөтөлбөрт тусгах. Бусад сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулахад Бизнесийн менежмент хөтөлбөр нь төслийн менежмент, бизнес план зэрэг тодорхой мэдлэг ур чадварыг олгодог хичээлүүдтэй тул тэр хичээлүүдээр дамжуулан идэвхтэй үйл ажиллагааг явуулах бодлогыг хөтөлбөрт нэмж оруулах нь зүйтэй.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн захиргааны зөвлөлийн шийдвэрийн дагуу “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам” батлагдсан ба түүний дагуу шийдвэрлэдэг байна. /энэ хөтөлбөрийн хүрээнд шилжилт хөдөлгөөн нэг

оюутан санхүү удирдлагаас бизнес удирдлага руу шилжсэн нь тайлангийн 111-р хуудаснаас харж болно/

- Магистр оюутан шилжилт хөдөлгөөн хийвэл судалсан хичээлийг дүйцүүлэн хаах боломжтой байдаг. Энэ талаар МУИС–ийн хэмжээнд баримтлах нэгдсэн журамтай байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хүрээнд мөрдөгддөг журамтай.

Анхаарах асуудал:

- Бизнесийн удирдлагаар суралцаж буй магистрын тоо бага байгаад анхаарах.

Зөвлөмж:

- Одоогоор бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрөөс гарч өөр хөтөлбөрт шилжин суралцагч гараагүй нь давуу тал гэж үзэж байгаа ч цаашид элсэн суралцагчийн тоог нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- “МУИС-ийн сургалтын журам” нь 2015 оны 6-р сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан ба журмын 4.12.4-р заалтанд төгсөлтийн бичиг баримтын талаар оруулсан байна. Энэхүү журамд амжилттай сурч дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэргийн болзол хангасан суралцагчид төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУИС-ийн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг олгоно гэж заасан байна.
- Өөрийн үнэлгээний тайланд нийт 65 хүн магистраар төгссөн гэж илтгэсэн байгаа ч баримт бичиг, протоколтой танилцахад нийт 81 хүн магистрын хөтөлбөрийг төгссөн болох нь батлагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичиг болох дипломоос харахад судалгааны болон мэргэжлийн магистрыг ялгаж салгасан мэдээлэл дутмаг байна.

Зөвлөмж:

- Төгсөлтийн баримт бичиг /диплом/-д судалгааны болон мэргэжлийн магистрын ялгааг илтгэсэн үг өгүүлбэр оруулах нь зүйтэй байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 5 шаардлагын 3-ыг бүрэн хангаж, 1-ийг хэсэгчлэн, 1-ийг хангаагүй тул нийтэд нь **ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн бодлогын бичиг баримтууд хангалттай ч тайлангууд энэ тэнд холилдон орсон. /МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр 201-2024/
- Тэнхимийн багш нарын 63,6% докторын зэрэгтэй. /одоогийн байдлаар нийт 22 багшаас 14 нь доктор, 8 магистр байгаагаас 4 нь докторант/
- Сүүлийн 5 жилд нийтдээ 81 төгсөгч бэлтгэсэн ба багш суралцагчийн тооны зохистой харьцаа баримтлагдсан байна /Хүснэгт 6.7/.
- Багшийн цагийн ачаалал, урамшууллыг нарийн бүртгэж тусгай хавтсанд хийдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын хувьд авч үзвэл гадны өндөр хөгжилтэй улс орнуудад суралцаж мэдлэг, боловсрол эзэмшсэн докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь өндөр байна. Багшийн хувийн хавтасны бүрдэл сайн байна.
- Багш нар сургалтаас гадна судалгаа шинжилгээний ажил хийх боломжтой, /багш нарын хавтсаас жил бүр оролцсон хурал семинар, ЭШБХ, судалгааны ажлын мэдээллийг харж болохоор байна/

Зөвлөмж:

- Багшийн хувийн хавтаснаас гадна тэнхимийн хүрээнд тавигдах шалгуурын дагуу хавтас бэлтгэн цэгцтэй баримт материал бүрдүүлж байх шаардлагатай байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн багшийг хөгжүүлэх бодлого, хөгжлийн хөтөлбөр, журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгаа, хөгжлийн асуудлыг дэмжин ажилладаг байна. Профессор

- багш 2 сая, дэд профессор 1 сая төгрөгийн сантай бөгөөд тодорхой нөхцөлүүдээр захиран зарцуулах эрхтэйгээр энэ мөнгийг олгодог байна.
- Тэнхимийн хувьд багш нарыг гадаад болон дотоодын ЭШХ, сургалт, семинарт тогтмол оролцуулдаг ба жил бүрийн тайланд мэдээллийг хүснэгтлэн оруулсан байна.
 - Багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн сайшааж, МУИС-ийн захирлын 2019 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн А/52 тоот тушаалаар батлан гаргаж хэвлүүлэн гарын авлага болгон багш нарт тараасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжил, ачаалал, урамшууллыг МУИС-ийн хэмжээнд бүрэн дэмжиж ажилладаг нь зөвхөн гаргасан дүрэм журмаас гадна хэрэгжүүлсэн ажлын тайлангаас харж болохоор байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын хувийн хавтасны мэдээллээс үзвэл тодорхой ажлуудыг хичээлээс гадуур хийж гүйцэтгэдэг. Түүнийгээ баримтжуулсан байх шаардлагатай байна. /Багш зөвхөн хичээлийн цагийн ачааллаар хязгаарлагдах ёсгүй./

Зөвлөмж:

- Тэнхимийн багш нар үндсэн ажлын зэрэгцээ захиргааны, болон захиалгат судалгааны ажлуудыг ихээхэн хийдэг байна. Иймд эдгээр ажлаа тэнхимийн мэдээллийн санд бүртгэж байх шаардлагатай байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа багшийн хавтас болон тэнхимийн тайланд тусгагдсан байна.
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам шинэчлэн батлагдаж мөрдөж байна.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ байгаа боловч хөтөлбөрт өөрчлөн тусгагдсан байдал хараахан хангалттай бус.
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо хангалттай.

- Зарцуулсан төсөв, хөрөнгийн тайланг хавтаслан тайлагнасан байна. /мөн МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрт 6-8 хуудсанд нөхцөл байдлын шинжилгээ хийж танилцуулагдсан байна/

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар багаараа болон суралцагч нарыг оролцуулан захиалгат болон төслийн судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, нийтлүүлэн ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Маш их судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд хийгддэг боловч хөтөлбөрт түүний дагуу хийсэн даацтай өөрчлөлт харагдахгүй байна.

Зөвлөмж:

- МУИС-ийн захиргаанаас бодлого, төсөл хөтөлбөр, судалгааны ажлыг дүрэм, журмын хүрээнд дэмжин оролцдог болох нь илэрч байгаа ч мэргэжлийн тэнхим, багш нар тэрхүү судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнг сургалтын хөтөлбөртөө бодитойгоор оруулсан өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ, аттестачлал тогтмол явуулж үнэлдэг болох нь нотлогдож байна. Багшийн хавтаст төлөвлөгөө өөрийн үнэлгээ орсон бол тэнхимийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн үнэлгээний үр дүнгүүд дэлгэрэнгүй орсон байна.
- МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн дөрөвдүгээр бүлэгт профессор, багшийн цогц чадамжийн шаталсан тодорхойлолт /22-29р хуудас/, багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний загвар /39-40р хуудас/ зэрэг үнэлгээ болон мэдлэг чадвар, шаардлагатай холбоотой тодорхой заалтуудыг оруулж өгсөн нь сайшаалтай.
- Мөн оюутнуудаас багшийн заах ур чадвар, ёс зүйн талаар үнэлгээ авдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн 4-р бүлэгт тодорхой стандартуудыг оруулж өгсөн ба багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний

загваруудыг багшийн зэрэглэл тус бүр дээр тайлбарлан оруулсан байна. /өөрийн үнэлгээний тайлангийн 22-40р хуудас, Хүснэгт 4.1 “Профессор, багшийн цогц чадамжийн шаталсан тодорхойлолт/

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр батлагдан гарын авлага болон тараагдсан учраас мэргэжлийн тэнхимийн хувьд энэхүү стандарт, заалтын дагуу баримт бичгийн бүрдүүлэлт хийж, багш нарын хөгжлийг үнэлэн дүгнэх үйл ажиллагааг тогтмолжуулах

Зөвлөмж:

- МУИС-ийн хэмжээнд батлагдсан, багшийг үнэлэх дүгнэх дүрэм журам, багшийн хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын бичиг баримтууд хангалттай байгаа давуу талаа ашиглан мэргэжлийн тэнхимийн хувьд баримт бичгийн бүрдлээ хангаж, багш нараа үнэлж дүгнэх, аргачлал төлөвлөгөө боловсруулж ажиллах.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 4 шаардлагыг тус бүрд нь бүрэн хангасан тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөрүүдийг Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо боловсруулж, Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж, МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлуулах гэсэн шатлалтайгаар баталгааждаг байна.
- МУИС-ийн захирлын 2017 оны Б/500 тоот тушаалаар хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтсийг сургалтын бодлого зохицуулалтын албаны дэргэд байгуулсан. Тус хэлтэс нь сургалтын хөтөлбөрийг үүсгэх батлах өөрчлөхтэй холбоотой асуудлыг хариуцдаг байна. Мөн хөтөлбөрийг үнэлэх, дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд ороход заавар чиглэл өгөх зорилготой байдаг.
- МУИС-ийн хэмжээнд сургалтын хөтөлбөрийн хөгжлийг “Хөтөлбөрийн ерөнхий хороо” нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг бөгөөд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтаас илүүтэй хөтөлбөрийн давхцал, элсэлтгүй сургалтын хөтөлбөрүүд зэргийг түр болон бүрэн зогсоох, давхардлаас сэргийлэхэд гол анхаарлаа хандуулдаг байна.
- Харин Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо 2017 онд 5 удаа хуралдаж дараах асуудлуудыг авч хэлэлцсэн байна. Үүнд:

- Элсэгчдийн чанар, тоо зэргийг харгалзан шалгалтыг хэрхэн зохион байгуулж авах;
 - Сургалтын хугацаандаа төгсөөгүй магистр оюутны сургалтын төлөвлөгөөг дүйцүүлэн төгсгөх;
 - Хөтөлбөрийн нэрийг “Бизнесийн менежмент” болгох;
 - Магистрын шилжилтийн шалтгааныг шалгах;
 - Японы олон улсын их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт асуудлуудыг авч хэлэлцэн шийдвэр гаргасан байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын төлөвлөлт, хийгдсэн ажил, хяналт үр дүнгийн талаар тайлангийн 138-139 дүгээр хуудас хүснэгт 7.2–т харуулсан байна.
 - Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хэрхэн хангаж ажилласан талаар өөрийн үнэлгээний тайлангийн 140-141 дүгээр хуудсанд толилуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн захирлын 2017 оны Б/500 тоот тушаалаар хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтсийг сургалтын бодлого зохицуулалтын албаны дэргэд байгуулсан. Тус хэлтэс нь сургалтын хөтөлбөрийг үүсгэх, батлах, өөрчлөхтэй холбоотой асуудлыг хариуцдаг байна. Мөн хөтөлбөрийг үнэлэх, дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд ороход заавар чиглэл өгөх зорилготой байдаг.
- Бизнесийн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо 2017 онд 5 удаа хуралдсан.

Анхаарах асуудал:

- “Бизнесийн менежмент” хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын талаар Бизнесийн хөтөлбөрийн хороо, МУИС-ийн хөтөлбөрийн хороо авч хэлэлцэж сайжруулалт, чанарын баталгаажуулалт хийсэн гэх зүйл баримтаар тогтоогдоогүй тул хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг дунд болон дээд шатны хөтөлбөрийн хороод анхаарал хандуулах шаардлагатай.

Зөвлөмж:

- МУИС-ийн сургалтын албаны дэргэдэх чанарын баталгаажуулалтын хэлтсийн ажиллах дүрэм журмыг тодорхой болгож, ажлын төлөвлөгөөг батлан үйл ажиллагааг идэвхжүүлэх.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Бизнесийн менежмент магистрын хөтөлбөрт элсэгчдийн 90 гаруй хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс байдаг тул төгсөж гарсны дараах ажлын байрны асуудал тулгардаггүй байна. Цөөн тооны оюутан бакалавр төгсөөд магистрын хөтөлбөрт элсэн ордог, тэдний ажлын байрны асуудал шийдвэрлэгддэг тул сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хөтөлбөр нийцэж байна гэж үздэг байна.
- Бизнесийн менежмент магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд 2019 онд судалгаа явуулсан 9 хүн судалгаанд хамрагдсан 2 хүн захирлын албан тушаалд дэвшсэн, үлдсэн 7 хүн суралцахаас өмнө хийж байсан албан тушаалдаа хэвээр байгаа бол төгсөгчидтэй хийсэн уулзалтаар магистрын сургалтад суралцаж төгссөний дараа ажлын байрны санал нийлээд олон газраас ирж байгаа тухай ярьж байв. Дээрх байдлууд нь тус хөтөлбөрөөр төгсөгчдийн эрэлт зохих түвшинд байгааг илтгэн харуулж байна.
- Хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангадаг гэсэн хариултыг ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн уулзалт баталж байна.
- МУИС-ийн өнөөгийн сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцоог өөрийн үнэлгээний тайлан Зураг 7.1-д дүрслэн харуулсан байна. Уг дүрслэлээс үзвэл Чанарын баталгаажуулалтын хэлтэс нь төлөвлөлтийн үе шатанд дараах асуудлуудыг багтаан авч үздэг байна.
 - Чанарыг сайжруулах, сонирхогч талуудын оролцоог хангах;
 - Чанарын хүрэх үр дүнг тодорхойлох;
 - Чанарын зорилго, үзэл баримтлал, зарчмыг тодохойлох;
 - Чанарын бодлогын баримт бичиг, арга зүйг бэлтгэх;
 - Чанарын асуудал хариуцсан хүний ажлын чиг үүргийг тодорхойлох;
 - Чанарын зорилтод түвшинд хүрэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх;

Харин чанарын баталгаажуулалт хийх үе шатанд дараах асуудлуудыг хамааруулан авч үздэг байна. Үүнд:

- Багшлах нөөц, дэд бүтэц, чадамж бусад нөөц
- Сургалтын чанарын цогц үйл ажиллагааг дотоод гадаад мэдээлэл
- Чанартай холбоотой баримт бичгийн бүрдүүлэлт
- Сургалтын үйл ажиллагааны хяналт

Үнэлэх хэсэгт: Мониторинг, үнэлгээ, дотоод аудит гэсэн чиглэлтэй үйл ажиллагааг хамааруулна.

Шалгах хэсэгт: Сайжруулалт зохицуулалт хамаарах бөгөөд төлөвлөлтөөс, шалгах хүртэлх бүх процесс тасралтгүй явагдана гэж дүрслэн харуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг тэнхим нэгжийн хүрээнд хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн өнөөгийн сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцоог зураг 7.1-д дүрслэн харуулсан байна. /Өөрийн үнэлгээний тайлан 139 дүгээр хуудас/

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтүүд, үйл ажиллагааны удирдамж, ажлын төлөвлөгөөгүй байна.
- МУИС-ийн өнөөгийн сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцоог зураг 7.1-д дүрслэн харуулсан боловч газар дээрээ ажил болж хэрэгжсэн эсэх нь тодорхойгүй.

Зөвлөмж:

- МУИС-ийн хэмжээнд хөтөлбөрийн үнэлгээ болон чанарын баталгаажуулалтын талаар дүрэм журамтай болох шаардлагатай.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС сургалтын байгууллагын хувьд 2018 онд дотоодын магадлан итгэмжлэлийн байгууллага болох БМИҮЗ-ийн шийдвэрээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.
- Бакалаврын хөтөлбөрүүд дотоодын болон олон улсын хөндлөнгийн байгууллагаар орж магадлан итгэмжлэгдсэн байна.
- Харин магистрын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэх анхны алхам хийгдэж байгаа.
- “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөрийг дотоодын мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлэх, ажил олгогчид болон төгсөгчдийн саналыг авах асуудал хангалтгүй болох нь өөрийн үнэлгээний тайлан болон сургууль дээр очиж ажиллах явцад ажиглагдсан болно.

Шалгуурыг хангасан байдал: Шалгуурын үндсэн өгөгдлийг хангаж байгаа тул **Бүрэн хангасан** гэж дүгнэв.

Анхаарах асуудал:

- Бизнесийн менежмент магистрын сургалтын хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрүүлэх ямар ажил зохион байгуулсан, ямар байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээтэй эсэх нь тодорхойгүй.

Зөвлөмж:

- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгааг гаргах.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурт тавигдах 3 шаардлагыг тус бүрд нь хангасан тул **БҮРЭН ХАНГАСАН** гэж дүгнэв.

ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа гүй (0)	Үндэслэл шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3(6)	--	--	
2	Сургалтын үйл ажиллагаа	3(6)	--	--	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3(6)	--	--	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5(10)	--	--	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	3(6)	1(1)	1(0)	
6	Багшийн үйл ажиллагаа	4(8)	--	--	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3(6)	--	--	
	Дүгнэлт	Хөтөлбөрийг шинжээчдийн багаас БҮРЭН ХАНГАСАН гэж үнэлэв.			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Бизнесийн сургуулийн “Бизнесийн менежмент” магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Д.ДАЛХЖАВ

Шинжээчийн багийн гишүүн: М.БАНЗРАГЧ

Шинжээчийн багийн гишүүн: Б.АМАРСАНАА

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн ажлын байрны судалгааг гаргахдаа тодорхой ажлын байргүй хэдэн хүн элсээд, төгсөж гараад хэдэн хувь нь ажлын байртай болсон бэ? гэдгийг судалгаагаар нарийвчлан харуулбал тус хөтөлбөрийн үр өгөөж тодорхой харагдах боломжтой.
2. Ямар хичээлүүдээр ямар мэдлэгүүдийг олгох вэ? Ямар хичээлийн ажилбаруудаар ямар чадвар эзэмшүүлэх вэ? Оюутан төгсөөд гарахад ямар хандлага төлөвшсөн хүн байх вэ? гэдгийг харуулсан зураглал боловсруулбал элсэгчид болон ажил олгогчид илүү ойлгомжтой болох юм.
3. Харин мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт мэргэшүүлэх дадлагын цагийн багтаамжийг 4 багц цагаар төлөвлөж оруулсан нь академик чиглэлд илүү анхаарсан байж болзошгүй. Цаашид аль болох танхимын сургалтаас татгалзаж мэргэшүүлэх дадлага хийлгэх цагийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн орчинд илүү хандуулах.
4. Цаашид өөрийн үнэлгээний тайлан бэлтгэхдээ магистрын хөтөлбөрөөр суралцагч оюутныг төсөл хөтөлбөр гэрээт ажилд хэрхэн оролцуулж дадлагажуулдаг талаар тодорхой тоо баримттай оруулж байх.
5. Хөтөлбөрийн талаарх мэдээллийг элсэлтийн үед л олон нийтэд хүргэдэг байдлыг засах, цахим хэлбэрээр олон нийтэд байнга тогтмол хүргэдэг байх.
6. Судалгаанд суурилсан сургалтыг гол чиглэлээ болгож байгаа их сургуулийн хувьд 5 жилийн хугацаанд 81 магистр төсгөж байгаа нь хэт бага байгааг анхаарч /MBA/ мэргэжлийн магистрын элсэлтийг нэмэгдүүлэх
7. МУИС-ийн сургалтын албаны дэргэдэх чанарын баталгаажуулалтын хэлтсийн ажиллах дүрэм журмыг тодорхой болгож, ажлын төлөвлөгөөг батлан үйл ажиллагааг идэвхжүүлэх,

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

	Нэр	Албан тушаал	Зэрэг цол
1	З.Алтанчимэг	Багш	Доктор дэд профессор
2	Б.Болор	Багш	Доктор дэд профессор
3	Н.Сонинтамир	Багш	Доктор профессор
4	Н.Батдэлгэр	Багш	Доктор дэд профессор
5	Ш.Энхтуул	Багш	Багш докторант
6	Б.Лхамцэдэн	Багш	Ахлах багш доктор
7	Б.Пүрэвдорж	Багш	Багш магистр
8	Ж.Ариунаа	Багш	Багш магистр
9	Д.Энх-Отгон	Тэнхмийн эрхлэгч	Доктор дэд профессор
10	Ц.Цэвээн	Багш	Доктор профессор
11	Д.Чимгээ	Багш	Доктор профессор
12	Ж.Сарантуяа	Багш	Ахлах багш докторант

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Мэргэжил курс	Сонгосон байдал холбоо барих утас
1	Э.Мөнхсүх	Менежмент магистр	99104359 суралцагч /судалгааны/
	Б. Билгүүн	Менежмент магистр	89006210 суралцагч
	Л.Ангарагмаа	Менежмент магистр	89110229 суралцагч
	А.Эрдэнэбаяр	Менежмент магистр	94448977 суралцагч
	Г.Түвшин	Менежмент магистр	88002224 суралцагч /мэргэжлийн/
	Б.Арман	Менежмент магистр	
	Б.Балжинням	Менежмент магистр	

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	н.Бат-Эрдэнэ	Моншибаси	
2	М.Халиунбат	Нийслэл хот	Нийслэлийн засаг даргын орогч
3	Д.Энхтуяа	Үндэсний хөгжлийн газар	
4	Адъяадорж	"Sky Garden Residence"	маркетинг борлуулалтын албаны менежер
5	Ц.Мөнхбат	"Энх-Мөнх хатад ХХК"-	
6	Ц.Мэндбаяр	Хот төлөвлөх хүрээлэн-	
7	Б.Мөнх-Од	Петростар ХХК-	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

11201 Улаанбаатар хот-46а ш/н-450, Сурбодорь-Эгүрэг,
Баян хоёруу 4, Утас/Факс: (976-11) 36-09-34,
E-mail: ba@msu.edu.mn, http://msu.dtu.edu.mn


2019.10.16 № 8/334

Угний _____ -ын № _____

БЛЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Бизнесийн менежмент
(E04130201)-ийн магистрын хөтөлбөрийг магадлан
итгэмжлэх шилжээчдийн дүгнэлтэнд өгөх саналыг
үүгээр хүргүүлж байна.

ЗАХИРАЛ



Н.ЭНХБАЯР

33400152

МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН БИЗНЕСИЙН МЕНЕЖМЕНТ
МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙГ (E04130201) МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТЭД ӨГӨХ САНАЛ

2019.10.16

МУИС-БС-ийн Бизнесийн менежментийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчийн багийн дүгнэлттэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Шинжээчийн зүгээс шалгуур тус бүрээр үзүүлэлт нотолгоо, онцлог зүйл/туршлага, анхаарах асуудал, зөвлөмж гэсэн хэсгүүдээр дүгнэлтээ ирүүлжээ. Шинжээчийн өгсөн санал дүгнэлт, сайжруулах зөвлөмжүүдийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж /тэнхим/, БС-ийн удирдлага санал нэгтэй хүлээн авч дараах чиглэлээр цаашдын бодлого, үйл ажиллагааны зорилт төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх болно гэдгээ илэрхийлж байна. Үүнд:

- ✓ Магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн ажлын байрны судалгааг гаргахдаа тодорхой ажлын байргүй хэдэн хүн элсээд, төгсөж гараад хэдэн хувь нь ажлын байртай болсон бэ гэдгийг нарийвчлан харуулах;
- ✓ Оюутан төгсөөд гарахад ямар хичээлүүдээр ямар мэдлэг, ямар чадвар эзэмшүүлэх, хандлага төлөвшсөн хүн байх вэ гэдгийг харуулсан зураглал боловсруулах /бичгээр бол байгаа/;
- ✓ Мэргэжлийн магистрын сургалтын хөтөлбөрт мэргэшүүлэх дадлагын танхимын цагийг багасгаж, мэргэшүүлэх дадлага хийлгэх цагийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн орчинд илүү хандуулах, цаашид сургалтын хөтөлбөр дэх дадлагын багц цагийг нэмэгдүүлэх;
- ✓ Өөрийн үнэлгээний тайлан бэлтгэхдээ магистрын хөтөлбөрөөр суралцагч оюутныг төсөл, хөтөлбөр гэрээт ажилд хэрхэн оролцуулж дадлагажуулдаг талаар тодорхой тоо баримттай оруулж байх;
- ✓ Хөтөлбөрийн талаарх мэдээллийг зөвхөн элсэлтийн үед л олон нийтэд хүргэдэг байдлыг засч, цахим хэлбэрээр олон нийтэд тогтмол түгээдэг байх;
- ✓ Судалгаанд суурилсан сургалтыг гол чиглэлээ болгоход анхаарах, магистрын элсэлтийг нэмэгдүүлэх;
- ✓ МУИС-ийн Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн ажиллах дүрэм журмыг тодорхой болгож, ажлын төлөвлөгөөг батлан үйл ажиллагааг идэвхжүүлэх
- ✓ Шаардлагатай програм хангамжийг худалдан авахад сургуулийн зүгээс дэмжлэг үзүүлэх, бусад нөөц боломжуудыг эрэлхийлэх талаар тодорхой ажил төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- ✓ Ном, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүний талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хэлэлцдэг, гарсан асуудлыг шийдвэрлэх тал дээр номын сантай хамтран ажиллах зэрэг болно.

ЗАХИРАЛ



Ч.ЭНХБАЯР

МЕНЕЖМЕНТИЙН
ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ



Д.ЭНХ-ОТГОН

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/